

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Захиалагч: Байгаль орчин,
аялал жуулчлалын яам,
Ойн бодлого зохицуулалтын газар

Гүйцэтгэгч:
“Өмгөөллийн ивээл баг”
хуулийн нөхөрлөл

Улаанбаатар хот,
2022 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ	3	
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3	
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3	
УДИРТГАЛ	4-5	2
НЭГ.ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ	5-9	
1.1.Үнэлгээ		
1.2.Дүгнэлт		
ХОЁР.ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ	9-14	
2.1.Үнэлгээ		
2.2.Дүгнэлт		
ГУРАВ.ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ	14-16	
3.1.Үнэлгээ		
3.2.Дүгнэлт		
ДӨРӨВ.ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ БАЙДАЛ	16-18	
4.1.Үнэлгээ		
4.2.Дүгнэлт		
ТАВ.ХАРИЛЦАН УЯЛДАА	18-27	
5.1.Үнэлгээ		
5.2.Дүгнэлт		
НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	27-28	
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	29	
ХАВСРАЛТ	30-37	
1.ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн тэмдэглэл		
2.Судалгааны маягт		

ТОВЧИЛСОН ҮГ

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ОМБ	Ойн мэргэжлийн байгууллага
ОБЗГ	Ойн бодлого зохицуулалтын газар
ОтХ	Ойн тухай хууль
ОСХТ	Ойн судалгаа хөгжлийн төв
ТЗТБ	Төрийн захиргааны төв байгууллага

3

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1 дүгээр хүснэгт.	Ойн асуудал хариуцсан ТЗБ-ын бүрэн эрхийн шинжилгээ
2 дугаар хүснэгт.	Хуулийн төсөл нь эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх үнэлгээ
3 дугаар хүснэгт.	Хуулийн төсөл нь хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх үнэлгээ
4 дүгээр хүснэгт.	Хуулийн төслийн уялдаа холбоог үнэлэх үнэлгээ
5 дугаар хүснэгт.	Хуулийн төсөлд давхардал байгаа эсэхийг шалгах үнэлгээ
6 дугаар хүснэгт.	Хуулийн төсөл дэх захиргааны хэм хэмжээний актын зохицуулалт

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1 дүгээр зураг.	Зорилгод хүрэх байдлын үнэлгээ (тоогоор)
2 дугаар зураг.	Практикт хэрэгжих боломжийн үнэлгээ (тоогоор)
3 дугаар зураг.	Ойлгомжтой байдлын үнэлгээ (тоогоор)
4 дүгээр зураг.	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ (тоогоор)
5 дугаар зураг.	Судалгааны үр дүн (тоогоор)

УДИРТГАЛ

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу төслийн үр нөлөөний үнэлгээ хийв. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний зорилго нь:

-хуулийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдааг тооцож шинжилгээ хийх;

-хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

-хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох;

-хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг шалгуур үзүүлэлтийг сонгох, хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоох, шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох, үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн дөрвөн үе шатаар хийнэ. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан уялдаа гэсэн таван шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тогтов.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтооход үр дагавар шууд үүсгэж байгаа, ач холбогдолтой зохицуулалтыг сонгон авах бөгөөд хуулийн төслийг бүхэлд нь эсхүл, тодорхой зохицуулалтын үр нөлөөг үнэлдэг. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь ойн асуудал хариуцсан ТЗБ байгуулах, ОМБ-ын магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжих, модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх болон ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим гэсэн үндсэн дөрвөн асуудлыг хөндсөн. Эдгээр зохицуулалт нь үр дагавар шууд үүсгэсэн, ач холбогдолтой байх тул хуулийн төсөлд бүхэлд нь үр нөлөөний үнэлгээ хийхээр тогтов.

Дээр дурдсан таван шалгуур үзүүлэлтийн хүрээнд зорилгод дүн шинжилгээ хийх, практикт турших, ойлгомжтой байдлыг шалгах, хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх, хуулийн төслийн уялдаа холбоог шалгах гэсэн шалгах хэрэгслээр хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ. Зорилгод дүн шинжилгээ хийх шалгах хэрэгслээр хуулийн төслийн үзэл баримтлал дахь хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар харьцуулан шинжилнэ. Практикт турших шалгах хэрэгслээр хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, этгээдээс санал авах замаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ. Ойлгомжтой байдлыг шалгах хэрэгслээр хуулийн төсөлд хамаарах этгээдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлно. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ойн асуудал хариуцсан ТЗБ-ын бүрэн эрхийг тусгасан тул хүлээн зөвшөөрөгдөх байдлыг шалгах хэрэгслийг ашиглан Ойн бодлого зохицуулалтын газар, Ойн судалгаа хөгжлийн төв, орон нутгийн байгаль орчны асуудал эрхэлсэн захиргааны байгууллага, ОМБ, ойн нөхөрлөлийн төлөөллийг оролцуулсан цахим хэлэлцүүлэг зохион байгуулна. Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах хэрэгслээр хуулийн төслийг бүхэлд нь шалгах ба хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хуультай нийцэх байдлыг үнэлнэ.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	14.2, 14.3, 23.1, 23.3, 23.4, 23.5, 30 ^{1.1} , 30 ^{1.7}	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	14.2, 23.4, 23.5, 30 ^{1.1} , 30 ^{1.3} , 30 ^{1.4} , 30 ^{1.7} , 38.5	Практикт турших
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	14.2	Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах
5.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

5

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2022.02.28-ны өдөр БОАЖЯ-ны ОБЗГ-тай хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт оролцогчид ОтХ-ийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, зарчмын санал гарсныг хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгасан. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх зорилгоор орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ойн анги, ойн нөхөрлөл, ОМБ-ын ажилтнуудаас судалгаа авсан. Судалгаанд орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ойн анги, ОМБ, ойн нөхөрлөл, мод үржүүлгийн газрын төлөөлөл болох 13 этгээд оролцсон. Судалгааны үр дүнг бүлэг бүрд тодорхойлсон. (хэлэлцүүлгийн тэмдэглэл, судалгааны маягтыг хавсралтаас үзнэ үү.)

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг дээр дурдсан шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгслийг ашиглан үнэлж дүгнэн, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж санал болгоно.

Нэг.Зорилгод хүрэх байдал

1.1.Үнэлгээ

Үр нөлөөг үнэлэх хэсэг	<p>Нэг.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</p> <p>14.2.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>14.2.1.ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг хангах;</p> <p>14.2.2.модлог ургамлын үрийн улсын нөөцийн сан байгуулах, тогтмол баяжуулах, үйл ажиллагааг нь хариуцах, үржлийн материал үйлдвэрлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;</p> <p>14.2.3.үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, сорилт, туршилт судалгааны лаборатори, хяналт шинжилгээний алба ажиллуулах;</p> <p>14.2.4.улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах;</p> <p>14.2.5.ойн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах;</p> <p>14.2.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>14.2.7.ашиглалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх;</p>
-------------------------------	--

14.2.8.энэ хуулийн 7.2-т заасны дагуу ойн тооллого, ойн зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сангийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх;

14.2.9.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах;

14.2.10.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;

14.2.11.модлог ургамлын үр, үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загварыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.2.12.улсын хэмжээнд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх;

14.2.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

14.2.14.мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;

14.2.15.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт, журам, заавар боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

14.2.16.ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал боловсруулах, батлах;

14.2.17.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

14.2.18.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх;

14.2.19.ойн ангийн дүрмийг батлах, даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх.

14.3.Ойн менежментийг сайжруулах, нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн нэгж ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтцэд байна.

Хоёр.Ойн мэргэжлийн байгууллагын магадлан итгэмжлэл

23.1.Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг эрхлэхээр энэ хуулийн 23.3-т заасан журмын дагуу магадлан итгэмжлэлд хамрагдан гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойн мэргэжлийн байгууллага гэнэ.

23.3.Ойн магадлан итгэмжлэлд тавигдах шаардлага, магадлан итгэмжлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

23.4.Ойн магадлан итгэмжлэлийг төр болон хувийн хэвшлээс хараат бус, гишүүнчлэлгүй нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гүйцэтгэнэ.

23.5.Магадлан итгэмжлэлийн дүгнэлтийг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн авч гэрчилгээ олгоно.

Гурав.Модлог ургамлын үр, үржлийн материал

	30 ¹ .1.Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд зөвхөн тухайн бүс, нутгийн байгалийн ойн гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан ойн үржлийн материалыг тариална. 30 ¹ .7.Тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн улсын нөөцийн санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно.
Шалгах хэрэгсэл	Зорилгод дүн шинжилгээ хийх
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	1.Ойн асуудал хариуцсан ТЗБ нь зорилгодоо хүрэх боломжтой эсэх? 2.Ойн мэргэжлийн байгууллагын магадлан итгэмжлэл нь зорилгодоо хүрэх боломжтой эсэх? 3.Модлог ургамлын үр, үржлийн материалын зохицуулалт нь зорилгодоо хүрэх боломжтой эсэх?

7

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд ТЗТБ-ын тодорхой бүрэн эрхийн зөвхөн 33 хувь нь яамны эрхлэх нийтлэг эрх байна гэсэн дүн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр гарсан хэмээн дурджээ. Биологи хийгээд сортын шинжийг хадгалсан модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх, сайн чанарын үрээр ойн үрийн нөөцийн сан бүрдүүлэх зэрэг ойн үрийн талаарх бодлого, зохицуулалт өнөөг хүртэл ОтХ-д тусгагдаагүй иржээ. Иймд модлог ургамлын үр, үржлийн материалын үйлдвэрлэлд төрийн дэмжлэг, зохицуулалт шаардлагатай байна. ТЗТБ-аас олгож байгаа ойн мэргэжлийн байгууллагын эрхийг иргэн, хуулийн этгээд хуулиар хориглоогүй ажил үйлчилгээг чөлөөтэй эрхлэх, төрийн байгууллага, албан тушаалтнаас олгох эрх, лицензийн тоог бууруулах, төрийн ажил үйлчилгээ хүндрэлгүй, шуурхай, хүртээмжтэй байх бодлого, зарчимд нийцүүлэн магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжүүлж шинэчлэх шаардлага үүсээд байна.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь ойн асуудал хариуцсан ТЗБ-ын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, бүрэн эрхийг тодорхойлох, ойн үрийн талаарх бодлого, зохицуулалтыг тусгах, мэргэжлийн байгууллагын эрх олгох тогтолцооноос магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжүүлж, төрийн ажил үйлчилгээ хүндрэлгүй, шуурхай, хүртээмжтэй байх бодлого зарчимд нийцүүлэхэд оршино.

Хуулийн төслөөр байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал хариуцсан ТЗБ ажиллана гээд төслийн 14.2 дахь хэсэгт уг байгууллагын хэрэгжүүлэх 19 бүрэн эрхийг тодорхойлжээ. Ойн асуудал хариуцсан ТЗБ нь БОАЖЯ-ны бүрэн эрхээс яамны эрхлэх нийтлэг асуудалд үл хамаарах бүрэн эрхийг¹ хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгажээ. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг улсын хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэхэд ойн менежментийг сайжруулах, ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх болон үрийн асуудал чухал ач холбогдолтой. Ойн агентлагийн бүрэн эрхэд ойн нөөцийг хаягдалгүй ашиглах, ойн менежментийг сайжруулахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, ойн үрийн улсын нөөцийн сан байгуулах, баяжуулах, үрийн судалгааны лаборатори ажиллуулах зэрэг зохицуулалтыг заажээ. Ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх үүрэг бүхий нэгж ойн асуудал хариуцсан ТЗБ-ын бүтцэд байхаар зохицуулсан нь уг чиг үүрэг тогтмол, тасралтгүй хийгдэх баталгааг хангасан хэмээн үнэлж байна.

Хуулийн төслөөр ойн магадлан итгэмжлэлд хамрагдан гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллагын ойн мэргэжлийн байгууллага гэнэ хэмээн заасан нь ойн мэргэжлийн байгууллагын эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн ТЗТБ-аас хуулийн дагуу авдаг

¹ Монгол Улсын Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. Улаанбаатар хот, 2021 он

байсан тогтолцоонд зарчмын зохицуулалт хийжээ. Ойн магадлан итгэмжлэлийг төр болон хувийн хэвшлээс хараат бус, гишүүнчлэлгүй, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гүйцэтгэхээр заасан нь төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх бодлого, зарчимд нийцсэн байна. Ойн магадлан итгэмжлэлд тавигдах шаардлага, журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн ТЗТБ батална. Төрийн бус байгууллага нь БОАЖЯ-наас батлагдсан журмыг баримтлан ойн байгууллагыг магадлан итгэмжилж дүгнэлт гаргана. Ойн магадлан итгэмжлэлийн дүгнэлтийг үндэслэн ойн асуудал хариуцсан ТЗБ ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ олгохоор байна. Байгаль орчны асуудал эрхэлсэн ТЗТБ нь ойн магадлан итгэмжлэлийг гүйцэтгэх төрийн бус байгууллагыг олон нийтэд нээлттэй, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой байдлаар сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, талуудын эрх, үүрэг, хариуцлагын асуудлыг гэрээгээр тохиролцож ажиллахыг зөвлөж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн улсын хэмжээнд амжилттай хэрэгжих эсэх нь модлог ургамлын үр бэлтгэх тогтолцоо, сайн чанарын үрийн хангалтаас шууд хамаарна. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 30¹ дугаар зүйлээр модлог ургамлын үр, үржийн материал бэлтгэх харилцааг зохицуулжээ. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд зөвхөн тухайн бүс, нутгийн байгалийн ойн гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан ойн үржлийн материалыг тариална, тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн улсын нөөцийн санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгажээ. Түүнчлэн модлог ургамлын үрийн улсын нөөцийн санг чанар сайтай үрээр бүрдүүлэх, үрийн улсын нөөцийн санг ойн үрийн төв лаборатори эрхлэх, гарал үүслийн болон чанарын гэрчилгээтэй үрийг худалдахаар заасан болно. Модлог ургамлын үр, үржлийн материалын үйлдвэрлэл нь багагүй хөрөнгө зардал, хүн хүч, цаг хугацаа шаарддаг ажил тул төрийн ивээлд байхаар тусгасан нь модлог ургамлын үр бэлтгэх үйлдвэрлэлийг дэмжсэн зохицуулалт болжээ. Энэ хүрээнд модлог ургамлын үр бэлтгэлд төрөөс үзүүлэх дэмжлэгийг байгаль орчны асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах журмаар нарийвлан зохицуулна.



1 дүгээр зураг. Зорилгод хүрэх байдлын үнэлгээ (тоогоор)

Судалгаанд оролцогчдын 85 хувь ойн асуудал хариуцсан ТЗБ зорилгодоо хүрэх боломжтой гэж, 46 хувь нь ойн байгууллагын магадлан итгэмжлэл зорилгодоо хүрэх боломжтой гэж, 62 хувь нь модлог ургамлын үрийн зохицуулалт зорилгодоо хүрэх

боломжтой гэж хариулжээ. Ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн зохицуулалтыг сайжруулах шаардлага байгааг судалгааны дүн харуулж байна.

1.2.Дүгнэлт

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр ойн асуудал хариуцсан ТЗБ байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, бүрэн эрхийг тодорхойлжээ. Ойн асуудал хариуцсан ТЗБ нь хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх зорилгодоо хүрэх боломжтой болох нь төслийн үр нөлөөний үнэлгээгээр тогтоогдлоо.

9

Ойн байгууллагын магадлан итгэмжлэлийг төр болон хувийн хэвшлээс хараат бус, гишүүнчлэлгүй, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гүйцэтгэх зохицуулалт нь төрийн байгууллагын ажил үйлчилгээ хүндрэл чирэгдэлгүй, хурдан шуурхай, хүртээмжтэй байх бодлого, зарчимд нийцсэн байна. Ойн магадлан итгэмжлэл хийх төрийн бус байгууллага нь байгаль орчны асуудал эрхэлсэн ТЗТБ-аас батлагдсан журмын хүрээнд магадлан итгэмжлэлийг зохион байгуулан дүгнэлт гаргах, ойн асуудал хариуцсан ТЗБ нь уг дүгнэлтийг үндэслэн ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ олгоно. Судалгааны үр дүнгээр ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн зорилгодоо хүрэх боломжтой байдлыг 46 хувь хэмээн үзсэн тул энэ зохицуулалтыг анхаарах шаардлага байна.

Модлог ургамлын үр, үржлийн материалын үйлдвэрлэл төрийн ивээлд байж, төрөөс тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэх, улмаар ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд зөвхөн тухайн бүс нутгийн чанарын шаардлага хангасан үрийг тариалах, модлог ургамлын үрийн чанарыг ойн үрийн төв лаборатори шинжлэх, улмаар гарал үүслийн болон чанарын гэрчилгээ олгох, гэрчилгээгүй үрийг худалдан борлуулахыг хориглох зохицуулалттай байна. Модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх бодлого хэрэгжүүлэх, үрийн улсын нөөцийн сан байгуулах, сорилт судалгааны лаборатори ажиллуулах үүргийг ойн асуудал хариуцсан ТЗБ хүлээнэ. Модлог ургамлын үр, үржлийн материалын зохицуулалт нь зорилгодоо хүрэх боломжтой болох нь ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээгээр тогтоогдож байна.

Хоёр.Практикт хэрэгжих боломж

2.1.Үнэлгээ

Үр нөлөөг үнэлэх хэсэг	Нэг.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 14.2.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.1.ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг хангах; 14.2.2.модлог ургамлын үрийн улсын нөөцийн сан байгуулах, тогтмол баяжуулах, үйл ажиллагааг нь хариуцах, үржлийн материал үйлдвэрлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх; 14.2.3.үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, сорилт, туршилт судалгааны лаборатори, хяналт шинжилгээний алба ажиллуулах; 14.2.4.улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах;
-------------------------------	--

- 14.2.5.ойн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах;
- 14.2.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
- 14.2.7.ашиглалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх;
- 14.2.8.энэ хуулийн 7.2-т заасны дагуу ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сангийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх;
- 14.2.9.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 14.2.10.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;
- 14.2.11.модлог ургамлын үр, үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загварыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 14.2.12.улсын хэмжээнд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх;
- 14.2.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;
- 14.2.14.мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;
- 14.2.15.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт, журам, заавар боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;
- 14.2.16.ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал боловсруулах, батлах;
- 14.2.17.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- 14.2.18.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх;
- 14.2.19.ойн ангийн дүрмийг батлах, даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх.

Хоёр.Ойн мэргэжлийн байгууллагын магадлан итгэмжлэл

- 23.4.Ойн магадлан итгэмжлэлийг төр болон хувийн хэвшилээс хараат бус, гишүүнчлэлгүй нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гүйцэтгэнэ.
- 23.5.Магадлан итгэмжлэлийн дүгнэлтийг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн авч гэрчилгээ олгоно.

Гурав.Модлог ургамлын үр, үржлийн материал

- 30¹.1.Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд зөвхөн тухайн бүс, нутгийн байгалийн ойн гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан ойн үржлийн материалыг тариална.

	30 ¹ .3.Байгалийн гамшгийн улмаас үр нөөцөлж чадаагүй, эсхүл үрийн бага ургацын жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилгоор удамшлын болон тарилтын сайн чанарын үрээр модлог ургамлын үрийн улсын нөөцийн санг бүрдүүлнэ. 30 ¹ .4.Модлог ургамлын үрийн улсын нөөцийн санг ойн үрийн төв лаборатори эрхэлнэ. 30 ¹ .7.Тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн улсын нөөцийн санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно.
Шалгах хэрэгсэл	Практикт турших
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	1.Ойн асуудал хариуцсан ТЗБ нь бүрэн эрхээ практикт хэрэгжүүлэх боломжтой эсэх? 2.ОМБ-ын магадлан итгэмжлэлийг практикт хэрэгжүүлэх боломжтой эсэх? 3.Модлог ургамлын үр, үржлийн материалын зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой эсэх?

Ойн асуудал хариуцсан ТЗБ нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний харьяанд байгуулагдан ажиллах ба Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод бүтэц болох Ойн бодлого зохицуулалтын газар болон Ойн судалгаа хөгжлийн төвд түшиглэн байгуулахаар ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгажээ. 2007 оны Ойн тухай хуульд байгаль орчны асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал эрхэлсэн ТЗБ ажиллана гэж тусгагдсан. УИХ-ын 2008.05.16-ны өдрийн 35 дугаар тогтоолоор ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг хэсэгт байгаль орчны эрхлэх асуудлын хүрээнд “Ойн хэрэг эрхлэх газар” гэж нэмж, ЗГ-ын 2008.06.02-ны өдрийн 212 дугаар тогтоолоор “Ойн хэрэг эрхлэх газар агентлаг” байгуулагдсан. Улмаар ЗГ-ын 2008.12.24-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор “Ойн хэрэг эрхлэх газар”-ыг “Ойн агентлаг” нэртэй болгон байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинэчлэн байгуулсан бөгөөд “Ой, усны хайгуул судалгааны төв”-ийг татан буулгаж, чиг үүргийг нь Ойн газарт шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл, ойн асуудал хариуцсан ТЗБ-ыг яамны дотоод бүтэц болох төвтэй нэгтгэн байгуулж байсан туршлага байна.

Ойн асуудал хариуцсан ТЗБ-ын бүрэн эрхийн дийлэнхийг ОБЗГ, ОСХТ хэрэгжүүлдэг.

1 дүгээр хүснэгт.Ойн асуудал хариуцсан ТЗБ-ын бүрэн эрхийн шинжилгээ

Д/д	Хуулийн төсөлд тусгагдсан ойн асуудал хариуцсан ТЗБ-ын бүрэн эрх	ОтХ-ийн зүйл, заалт	Хэрэгжүүлдэг субъект
1.	14.2.1.ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг хангах;	13.1.1.	ОБЗГ
2.	14.2.2.модлог ургамлын үрийн улсын нөөцийн сан байгуулах, тогтмол баяжуулах, үйл ажиллагааг нь хариуцах, үржлийн материал үйлдвэрлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;	13.1.20	ОБЗГ
3.	14.2.3.үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, сорилт, туршилт судалгааны лаборатори, хяналт шинжилгээний алба ажиллуулах;	13.1.34	ОСХТ
4.	14.2.4.улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах;		
5.	14.2.5.ойн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах;	13.1.9	ОБЗГ

6.	14.2.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;	13.1.18	ОБЗГ
7.	14.2.7.ашиглалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх;		
8.	14.2.8.энэ хуулийн 7.2-т заасны дагуу ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сан, нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх;	7.2	ОБЗГ
9.	14.2.9.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах;	13.1.21	ОБЗГ
10.	14.2.10.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;	13.1.23	ОБЗГ
11.	14.2.11.модлог ургамлын үр, үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загварыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;	22.3.	ОБЗГ
12.	14.2.12.улсын хэмжээнд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх;	13.1.11	ОБЗГ
13.	14.2.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;	13.1.31	ОБЗГ
14.	14.2.14.мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;	13.1.19	ОБЗГ
15.	14.2.15.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт, журам, заавар боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;	13.1.24	ОБЗГ
16.	14.2.16.ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал боловсруулах, батлах;	13.1.27	ОБЗГ
17.	14.2.17.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	13.1.29	ОБЗГ
18.	14.2.18.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх;	13.1.33	ОБЗГ
19.	14.2.19.ойн ангийн дүрмийг батлах, даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх.	13.1.22	ОБЗГ
20.	30 ¹ .2.Ойн үрийн мужлалын хилийн заагийг ойн шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн тогтооно.		
21.	30 ¹ .4.Модлог ургамлын үрийн улсын нөөцийн санг ойн үрийн төв лаборатори эрхэлнэ.	13.1.20	ОСХТ
22.	30 ¹ .7.Тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн нөөцийн улсын санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно.		ОСХТ

Ойн асуудал хариуцсан ТЗБ-ын хийх 22 ажлын 73 хувь буюу 16 ажлыг нь ОБЗГ, 13.5 хувь буюу 3 ажлыг нь ОСХТ, 13.5 хувь буюу 3 ажил нь шинээр нэмэгдсэн ажил байна. Иймд шинээр байгуулагдах ойн асуудал хариуцсан ТЗБ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэхгүй хэмээн үзэж байна. Ойн судалгаа хөгжлийн төвөөс ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал авахад тусгайлан өгөх саналгүй, дэмжиж байгаа тухай хариуг 2022.02.28-ны өдрийн 1/29 дүгээр албан бичгээр ирүүлсэн болно.

Ойн магадлан итгэмжлэлийн талаар өнгөрсөн хугацаанд багагүй төсөл хөтөлбөр хэрэгжжээ. Магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжихэд түүнийг гүйцэтгэх субъект, хүний нөөц, хөрөнгө санхүү, техник технологийн нөөц бололцоог сайтар нягталсны үндсэн дээр эхлэх хугацааг зөв тогтоон хэрэгжүүлэх нь зүйтэй болно.

Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд гарал үүсэл тодорхой, чанарын шаардлага хангасан үрийг тариалах, худалдах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй нөхцөлд худалдахыг хориглоно. Модлог ургамлын үрээс дээж авах, чанарыг шинжлэх зэрэг ажлыг ойн үрийн төв лаборатори гүйцэтгэж, гарал үүслийн болон чанарын гэрчилгээ олгоно. Энэ ажлыг ОСХТ одоогоор хийдэг.



2 дугаар зураг. Практикт хэрэгжих боломжийн үнэлгээ (тоогоор)

Судалгаанд оролцогчдын 85 хувь нь ойн асуудал хариуцсан ТЗБ-ын зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж, 38 хувь нь ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж, 54 хувь нь модлог ургамлын үрийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж, 46 хувь нь ойн дагалт баялгийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж хариулжээ.

2.2. Дүгнэлт

Ойн асуудал хариуцсан ТЗБ-ын бүрэн эрхийн 73 хувийг ОБЗГ, 13.5 хувийг ОСХТ, нийт 86.5 хувьд хамаарах ажил үүрэг нь одоогоор хийгддэг байна. Иймд ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээгээр ойн асуудал хариуцсан ТЗБ бүрэн эрхээ практикт хэрэгжүүлэх боломжтой нь тогтоогдов.

Ойн байгууллагын магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх нь төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бэхжүүлсэн, төрөөс олгох зөвшөөрөл, эрхийн тоог бууруулах бодлогод нийцсэн, ойн сайн засаглалын талаарх олон улсын

хандлагад ойртсон зохицуулалт болно. Байгаль орчны салбарт нийгэмд үйлчилдэг 600 гаруй төрийн бус байгууллага ажилладаг гэсэн тоо байна.² Иймд ойн магадлан итгэмжлэлийг практикт хэрэгжүүлэх этгээд байгаа бөгөөд тэдгээрийг магадлан итгэмжлэх талаар сургах, бэлтгэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах шаардлагатай болно. Судалгааны үр дүнгээр 50 хүрэхгүй хувьд нь ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж үзсэнийг анхаарах нь зүйтэй.

Модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх зохицуулалт нэн тулгамдсан асуудлын нэг бөгөөд ойн үрийн төв лаборатори үрээс дээж авч, шинжилгээ хийх, гарал үүслийн болон чанарын гэрчилгээ олгох ажлыг практикт хэрэгжүүлэх боломжтой нь үр нөлөөний үнэлгээгээр илэрсэн.

Гурав.Ойлгомжтой байдал

3.1.Үнэлгээ

<i>Үр нөлөөг үнэлэх хэсэг</i>	ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бүхэлдээ
<i>Шалгах хэрэгсэл</i>	Ойлгомжтой байдлыг судлах, Хамаарах этгээдээс ойлгомжтой эсэх, нэг мөр хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлох
<i>Томьёологдсон шалгуур үзүүлэлт</i>	1.Хуулийн төсөл ойлгомжтой томьёологдсон эсэх? 2.Хуулийн төсөл нь хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэх? 3.Хуулийн төсөл нь хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэх?

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ хийе.

2 дугаар хүснэгт.Хуулийн төсөл нь эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх үнэлгээ

Д/д	Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	Үнэлгээ (шаардлага хангасан эсэх)
1.	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
2.	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан.
3.	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
4.	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
5.	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
6.	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.

² Улсын бүртгэлийн ерөнхий газрын хувийн этгээлийн улсын бүртгэлийн мэдээллээс авч

7.	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан.
8.	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан.
9.	29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан.
10.	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан.
11.	29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.


15

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээгээр төсөл нь эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан болох нь тогтоогдож байна.

3 дугаар хүснэгт.Хуулийн төсөл нь хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх үнэлгээ

Д/д	Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	Үнэлгээ (шаардлага хангасан эсэх)
1.	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан.
2.	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
3.	30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан.
4.	30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
5.	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Уг шаардлагыг хангасан.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээгээр төсөл нь хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан болох нь тогтоогдож байна.



3 дугаар зураг. Ойлгомжтой байдлын үнэлгээ (тоогоор)

Судалгаанд оролцогчдын 38 хувь нь ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн зохицуулалт ойлгомжтой томъёологдсон гэж, 62 хувь нь модлог ургамлын үрийн зохицуулалт ойлгомжтой томъёологдсон гэж, 46 хувь нь ойн дагалт баялгийн зохицуулалт ойлгомжтой томъёологдсон гэж хариулжээ.

3.2. Дүгнэлт

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэллээ. Хуулийн үйлчлэлд хамрагдах этгээдээс санал авахад

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бичвэрийн агуулгад болон хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан болох нь үнэлгээгээр илэрсэн. Иймд ОтХ-ийн төсөл нь бүхэлдээ ойлгомжтой боловсруулагдсан хэмээн үзэж байна.

Дөрөв. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

4.1. Үнэлгээ

Үр нөлөөг үнэлэх хэсэг	<p>Нэг. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</p> <p>14.2. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>14.2.1. ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг хангах;</p> <p>14.2.2. модлог ургамлын үрийн улсын нөөцийн сан байгуулах, тогтмол баяжуулах, үйл ажиллагааг нь хариуцах, үржлийн материал үйлдвэрлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;</p> <p>14.2.3. үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, сорилт, туршилт судалгааны лаборатори, хяналт шинжилгээний алба ажиллуулах;</p> <p>14.2.4. улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах;</p> <p>14.2.5. ойн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах;</p> <p>14.2.6. улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p>
-------------------------------	---

	<p>14.2.7.ашиглалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх;</p> <p>14.2.8.энэ хуулийн 7.2-т заасны дагуу ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сангийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх;</p> <p>14.2.9.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах;</p> <p>14.2.10.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;</p> <p>14.2.11.модлог ургамлын үр, үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загварыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>14.2.12.улсын хэмжээнд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх;</p> <p>14.2.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>14.2.14.мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;</p> <p>14.2.15.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт, журам, заавар боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;</p> <p>14.2.16.ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал боловсруулах, батлах;</p> <p>14.2.17.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;</p> <p>14.2.18.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх;</p> <p>14.2.19.ойн ангийн дүрмийг батлах, даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх.</p>
Шалгах хэрэгсэл	Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг судлах
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	1.Ойн асуудал хариуцсан ТБЗ, түүний бүрэн эрхийг тодорхойлсон зохицуулалтыг үр дагаварт шууд хамаарах иргэн, хуулийн этгээд хүлээн зөвшөөрөх эсэх?


“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.8-д төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох нөхцөлд хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр төслийн үр нөлөөг үнэлэхээр заасан. Үнэлгээний явцад БОАЖЯ-ны ОБЗГ-ын албан тушаалтан, албан хаагч нартай уулзалт ярилцлага хийхэд хуулийн төслийн 14.2 дахь хэсгийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Түүнчлэн уг зохицуулалтад хамаарах нэг субъект нь ОСХТ бөгөөд тэднээс хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар санал авсан. ОСХТ нь хуулийн төслийг дэмжиж, хүлээн зөвшөөрч байгаагаа 2022.02.28-ны өдрийн 1/29 дүгээр албан бичгээр мэдэгдсэн.

ОтХ-ийн төслийг танилцуулах, үр нөлөөг үнэлэх зорилготой хэлэлцүүлгийг БОАЖЯ-ны ОБЗГ-тай хамтран 2022.02.28-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцсон. Хэлэлцүүлэгт оролцогчид ойн асуудал хариуцсан ТЗБ байгуулах, тэдний бүрэн эрхийг санал нэгтгэй дэмжсэн болно.

Судалгаанд оролцогчдын 85 хувь нь ойн асуудал хариуцсан ТЗБ-ыг хүлээн зөвшөөрөгдөх байдал хангалттай сайн хэмээн, 15 хувь нь дундаж түвшинд хэмээн үзжээ.

4.2.Дүгнэлт

Ойн асуудал хариуцсан ТЗБ байгуулагдах зохицуулалтыг үйлчлэлд хамаарах этгээд болох БОАЖЯ-ны ОБЗГ, ОСХТ хүлээн зөвшөөрч, дэмжиж байна. Хуулийн төслийн танилцуулга, үр нөлөөг тодорхойлох хэлэлцүүлгээр оролцогчид ойн агентлагийг байгуулагдах зохицуулалтыг дэмжсэн болно.



18

4 дүгээр зураг. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ (тоогоор)

Судалгааны дүнгээр дийлэнх буюу 85 хувь нь ойн асуудал хариуцсан ТЗБ-ын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг дэмжсэн байна. Иймд ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийг хангасан болох нь үр нөлөөний үнэлгээгээр тогтоогдож байна.

Тав.Харилцан уялдаа

5.1.Үнэлгээ

Үр нөлөөг үнэлэх хэсэг	Хуулийн төсөл бүхэлдээ
Шалгах хэрэгсэл	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	1.Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх? 2.Хуулийн төсөл нь төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх?

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх бөгөөд стандарт асуултад хариулах замаар үнэлгээ өгнө. Хуулийн төслийн уялдаа холбоог шалгаснаар хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах боломжтой.

Д/д	Стандарт асуулт	Хариулт (тийм, үгүй аль нь болохыг бичих)
1.	Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттойгоо нийцэж байгаа эсэх?	Тийм
2.	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх?	Тийм
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх?	Тийм
4.	Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн зохицуулалттай нийцэж байгаа эсэх?	Тийм
5.	Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн зохицуулалттай давхардсан эсэх?	Үгүй
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх?	Тийм
7.	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх?	Үгүй
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх?	Үгүй
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломж байгаа эсэх?	Үгүй
10.	Татварынхнаас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх?	Үгүй
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх?	Үгүй
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдсан эсэх?	Үгүй
13.	Хуулийн төслийн зохицуулалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх?	Тийм
14.	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх?	Үгүй
15.	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх?	Үгүй
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх?	Үгүй

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулах, модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх, ойн магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжих болон ойн дагалт баялаг болох самар тээвэрлэх харилцааг зохицуулсан. Эдгээр зохицуулалт нь ОтХ-ийн 1.1-д заасан Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилттой нийцэж байна. Хуулийн төсөлд “Хууль тогтоомж” гэсэн хэсэг тусгагдаагүй болно. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “модлог ургамлын үр”, “үржлийн материал”, “магадлан итгэмжлэл”, “модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх, боловсруулах”, “ойн үрийн мужлал”, “ойн аж ахуйн арга хэмжээ” гэсэн зургаан нэр томъёоны тодорхойлолт тусгасан. Нэр томъёо нь хуулийн төслийн бусад зохицуулалттай нийцэх бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, бусад хуультай зөрчилдөх байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төсөлтэй нийцэж байгаа бөгөөд бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөх байдал одоогоор илрээгүй болно.

Хуулийн төслөөр хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн ТЗТБ, ойн асуудал хариуцсан ТЗБ, ойн үрийн төв лабораторийн бүрэн эрхийг тодорхойлсон. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээг тодорхойлсон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд газар тариалан, бэлчээр, үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал хамаарахаар байна. ОтХ-д хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн ТЗТБ-ын бүрэн эрх хуульчлагдаагүй тул нэмж оруулахаар хуулийн төсөлд тусгасан нь хуулийн давхардал үүсэх нөхцөл болохгүй. Хуулийн төсөлд ойн асуудал хариуцсан ТЗБ нь 19 бүрэн эрх хэрэгжүүлэхээр тусгажээ.

20

5 дугаар хүснэгт.Хуулийн төсөлд давхардал байгаа эсэхийг шалгах үнэлгээ

Д/д	ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын бүрэн эрх	ОтХ-ийн төрийн байгууллагын бүрэн эрх	Давхардал бий эсэх (тийм, үгүй)	Тайлбар
Ойн асуудал хариуцсан ТЗБ		Ойн асуудал эрхэлсэн ТЗТБ		
1.	14.2.1.ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг хангах;	13.1.1.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой хээрийг түймрээс хамгаалах, байгаль орчны тэнцлийг хангах талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Үгүй	Яамны эрх зүйн байдлын тухай хууль, ЗГ-ын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуультай нийцнэ.
2.	14.2.2.модлог ургамлын үрийн улсын нөөцийн сан байгуулах, тогтмол баяжуулах, үйл ажиллагааг нь хариуцах, үржлийн материал үйлдвэрлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;	13.1.20.мод, сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх, мод үржүүлгийн газар байгуулах, тарьц, суулгац ургуулах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангах;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.20 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
3.	14.2.3.үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, сорилт, туршилт судалгааны лаборатори, хяналт шинжилгээний алба ажиллуулах;	13.1.34.өөрийн байгууллагын бүтцэд ойн судалгаа, хяналт шинжилгээний алба ажиллуулах;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.34 дэх заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
4.	14.2.4.улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах;	-	Үгүй	Шинээр нэмэгдсэн.

5.	14.2.5.ойн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах;	13.1.9.улсын ойн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих;	Үгүй	Өөр зохицуулалт болно. Агентлаг нь санг бүрдүүлэх, яам нь санг бүрдүүлэхэд хяналт тавих.
		13.1.25... ойн мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах ...;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.25 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
6.	14.2.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;	13.1.18.аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.18 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
7.	14.2.7.ашиглалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх;	-	Үгүй	Шинээр нэмэгдсэн.
8.	14.2.8.энэ хуулийн 7.2-т заасны дагуу ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сан, нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх;	7.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ойн тооллогыг таван жил тутам улсын хэмжээнд явуулж, ойн сангийн төлөв байдлыг шинэчлэн тогтооно. Ой зохион байгуулалтын ажлыг арван жил тутамд хийж, ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг шинэчлэн батална.	Үгүй	Ойн тооллого, ой зохион байгуулалтыг яамны шийдвэрийн дагуу агентлаг хэрэгжүүлнэ.
		13.1.25.ойн нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх, ...;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.25

				дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
9.	14.2.9.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах;	13.1.21.орон нутаг дахь ойн анги, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.21 дэх заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
10.	14.2.10.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;	13.1.23.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнах;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.23 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
11.	14.2.11.модлог ургамлын үр, үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загварыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;	22.3.Энэ хуулийн 22.1.9-д заасан гэрээ болон гэрчилгээний загварыг төрийн захиргааны төв байгууллага батална.	Үгүй	Өөр зохицуулалт. Агентлаг гэрчилгээн ий загварыг боловсруулж, яам батална.
12.	14.2.12.улсын хэмжээнд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх;	13.1.11.энэ хуулийн 7.4.1-д заасны дагуу улсын төсвөөс гаргах зардлын хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, биелэлтийг дүгнэн, ажил гүйцэтгэгчийг санхүүжүүлэх;	Үгүй	
13.	14.2.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг,	13.1.31.ой, хээрийн түймрийн аюултай үед тухайн бүс нутгийн түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаль орчинтой харьцах тодорхой үйл ажиллагааг зогсоох тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.31 дэх заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.

	нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;			
14.	14.2.14.мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;	13.1.19.мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах, төв, суурин газрыг цэцэрлэгжүүлэх ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.19 дэх заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
15.	14.2.15.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт, журам, заавар боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;	13.1.24.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар технологи, норм, нормативын үндэслэл боловсруулах, батлах;	Үгүй	Агентлаг захиргааны актын төсөл боловсруулж, яам батална.
16.	14.2.16.ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал боловсруулах, батлах;	13.1.27.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын явуулах үйл ажиллагааны хөтөлбөр, ойн ангийн эрхлэх ажил, үйлчилгээний чиглэл, ойн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар, журам батлах;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.27 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
17.	14.2.17.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	13.1.29.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга, ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.29 дэх заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
18.	14.2.18.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх;	13.1.33.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.33 дахь заалтыг хүчингүй

				болсонд тооцохоор тусгасан.
19.	14.2.19.ойн ангийн дүрмийг батлах, даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх.	13.1.22.ойн ангийн ажиллах журам, дүрмийг батлах;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.22 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
		17.2.8.аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоо батлан, тэдгээрийн даргыг байгаль орчны газрын даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 17.2.8 дахь заалтыг өөрчилсөн.
20.	30 ¹ .2.Ойн үрийн мужлалын хилийн заагийг ойн шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн тогтооно.	-	Үгүй	
Хэрэгжүүлэх субъект.Ойн үрийн төв лаборатори				
21.	30 ¹ .4.Модлог ургамлын үрийн улсын нөөцийн санг ойн үрийн төв лаборатори эрхэлнэ.	13.1.20.мод, сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх, мод үржүүлгийн газар байгуулах, тарьц, суулгац ургуулах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангах;	Үгүй	Хуулийн төсөлд ОтХ-ийн 13.1.20 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан.
22.	30 ¹ .7.Тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн нөөцийн улсын санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно.	-	Үгүй	Шинээр нэмэгдсэн.

Ойн асуудал хариуцсан ТЗБ болон ойн үрийн төв лабораторийн бүрэн эрх, үүргийг хуулийн төсөлд, ОтХ-д хэрхэн тусгагдсан байдлыг харьцуулан шинжилж үзэхэд хуулийн давхардал илрээгүй.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн байгууллагын бүрэн эрх, ойн магадлан итгэмжлэлийн зохицуулалтыг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгажээ. Тухайлбал: хөнгөн вйлдвэрлэл, хөлөө аж ахуйн асуудал эрхэлсэн ТЗБТ ойн

асуудал хариуцсан ТЗБ гэх мэт. Модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх болон ойн дагалт баялаг самар тээвэрлэх зохицуулалтад хийх ажлаар нь тусгасан байна. Жишээлбэл: хуулийн төслийн 30¹.1-д “Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд зөвхөн тухайн бүс, нутгийн байгалийн ойн гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан ойн үржлийн материалыг тариална.”, 30¹.8-д “Гарал үүслийн болон чанарын гэрчилгээтэй ойн үржлийн материалыг худалдан борлуулна”, 38.5-д “Хушны самрын дунд ургацтай жилд зөвхөн ахуйн зориулалтаар, их ургацтай жилд аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрөх бөгөөд үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн самрыг өөр сум, аймаг, хот руу тээвэрлэхэд энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-д заасан гарал үүсэл, чанарын гэрчилгээ авна.” гэжээ. Эдгээр зохицуулалтад хэрэгжүүлэх этгээдийг нэрлэн заагаагүй хэдий ч тухайн ажил, үйлдлийг хийх бүх этгээд буюу иргэн, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан хэн аль нь хамаарахаар зохицуулжээ. Иймд хуулийн төсөлд хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан хэмээн үзэв.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь үзэл баримтлалын хүрээнд буюу ойн асуудал хариуцсан ТЗБ байгуулах, ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжих, модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх болон ойн дагалт баялаг ашиглах гэсэн дөрвөн хүрээнд боловсруулагдсан байна. Хуулийн төсөлд долоон харилцааг нарийвчлан зохицуулсан захиргааны хэм хэмжээний акт батлах эрхийг яам, агентлагт олгохоор тусгажээ.

6 дугаар хүснэгт.Хуулийн төсөл дэх
захиргааны хэм хэмжээний актын зохицуулалт

Д/д	Захиргааны хэм хэмжээний актын зохицуулах харилцаа	Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	Батлах субъект
<i>Нэг.ТЗБТ хамтран батлах</i>			
1.	Модлог ургамлын үр, үржлийн материалын үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг	30 ¹ .6	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд
2.	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын норматив	30.6	Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
<i>Хоёр.ТЗТБ дангаар батлах</i>			
3.	Ойн магадлан итгэмжлэлд тавигдах шаардлага, магадлан итгэмжлэх журам	23.3.	БОАЖЯ
4.	Ойн аж ахуйн салбарын ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох журам	13.2.4.	ХХААХҮЯ
<i>Гурав.ТЗБ батлах</i>			
5.	Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал	14.2.16.	Ойн асуудал хариуцсан ТЗБ
6.	Ойн ангийн дүрэм	14.2.19.	
<i>Дөрөв.Нутгийн өөрөө удирдах байгууллага батлах</i>			
7.	Хандивын хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах, уг хөрөнгөөр мод тарьж ургуулах журам	31.5	Аймаг, нийслэлийн ИТХ

Ойн менежментийн төлөвлөгөө, ойн ангид холбогдох хоёр захиргааны актыг ойн асуудал хариуцсан ТЗБ, модлог ургамлын үр, үржлийн материалд төрөөс дэмжлэг үзүүлэх, ойжуулалтын зардлын нормативын хоёр захиргааны актыг БОАЖЯ болон Сангийн яам хамтран, ойн магадлан итгэмжлэх журмыг БОАЖЯ, ойн аж ахуйн салбарын

ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох журмыг ХХААХҮЯ, хандивын хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал батална. Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлан гаргах эрхийг тодорхой тусгасан тул шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж дүгнэв.

Хуулийн төслийн зохицуулалтыг хооронд нь болон бусад хуультай давхардах эсэхийг шинжилсэн шинжилгээний үр дүнгээр төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулсан асуудал тогтоогдоогүй болно. Ойн байгууллагын магадлан итгэмжлэлийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ хэмээн хуулийн төсөлд тусгасан нь төрийн чиг үүргийг төрийн бус хуулийн этгээдэд шилжүүлсэн зохицуулалт бөгөөд төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжийг хэрэглэсэн хэмээн үзлээ.

26

Хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж, тусгай зөвшөөрөл, Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байна. Шударга бус өрсөлдөөн, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй. Ойн асуудал эрхэлсэн ТЗТБ-аас эрх авсны үндсэн дээр ОМБ-ын үйл ажиллагаа явуулдаг байсныг өөрчилж, ойн магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжүүлэх зохицуулалт тусгагдсан нь шударга бус өрсөлдөөн, авлига, хүнд суртлаас сэргийлсэн алхам болжээ.


Хуулийн төсөлд хориглосон зохицуулалт нэг тусгагдсан нь төслийн 30¹.9-д “Гарал үүсэл тодорхойгүй, эсхүл үр нь лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй тохиолдолд тухайн багц үрийг худалдах, импортлохыг хориглоно.” гэж заасан болно. ОтХ-ийн 47 дугаар зүйлд энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд ойн тухай хууль тогтоомж зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг, Эрүүгийн хуулийн 211 дүгээр зүйлд Ойн тухай хууль тогтоомж зөрчихөд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг заажээ. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хориглосон зохицуулалтад хамаарах хариуцлага Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй байна.

5.2.Дүгнэлт

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр стандарт 16 асуултын дагуу үнэллээ. Аргачлалд заасан стандарт асуултын 94 хувь буюу 15 асуултад нь тухайн шаардлагыг хангасан буюу “эрэг” үр дүн гарсан. Стандарт асуултын 6 хувь буюу 1 асуултад нь тухайн шаардлагыг хангаагүй буюу “сөрөг” үр дүн гарав. Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлага тусгагдаагүй, тодорхой бус бөгөөд энэ талаар Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй байна.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн харилцан уялдааг шалгаад хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн, төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн зохицуулалт тогтоогдоогүй хэмээн үнэлсэн болно.

Үнэлгээ: 1.ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн байна;
2.ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн зохицуулалт тогтоогдоогүй болно.



5 дугаар зураг. Судалгааны үр дүн (тоогоор)

Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан уялдаа гэсэн таван шалгуур үзүүлэлтээр үр нөлөөний үнэлгээ хийлээ. Үр нөлөөний үнэлгээнд аргачлалаар тогтоосон шалгах асуултыг хэрэглэсэн бөгөөд хуулийн төслийн үйлчлэлд хамаарах этгээдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, судалгаа авсан болно.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж болно:

1. Хуулийн төсөл нь зорилгодоо хүрэх байдал нь эерэг;
2. Хуулийн төсөл нь практикт хэрэгжих боломжтой;
3. Хуулийн төсөл нь ойлгомжтой байдлаар боловсруулагдсан;
4. Хуулийн төслийн зохицуулалтын олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдал нь эерэг;
5. Хуулийн төсөлд хийсэн шинжилгээгээр төрийн байгууллагын чиг үүргийн давхардал, хийдэл, зөрчил илрээгүй;
6. Хуулийн төсөл нь хоорондоо болон бусад хуулийн зохицуулалттай харилцан уялдаатай байна.

Түүнчлэн судалгааны үр дүнгээс үзэхэд ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн зохицуулалтад анхаарах шаардлагатай байна. Ойн байгууллагын магадлан итгэмжлэл нь төрийн ажил үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх бодлого, зарчимд нийцэх хэдий ч хэрэгжүүлэх зохицуулалтыг сайжруулахыг зөвлөс.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан хуулийн төсөл батлагдсан тохиолдолд зорилгодоо хүрэх байдал нь эерэг, тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой, хуулийн төслийг хэрэглэх, хэрэгжүүлэх байгууллага түүнийг хүлээн зөвшөөрч байгаа тул ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэвээр үлдээхийг зөвлөж байна. Гэхдээ ойн байгууллагын магадлан

итгэмжлэлийг практикт хэрэгжүүлэх зохицуулалтыг сайжруулах өөрчлөлт оруулах боломжтой.



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг.Монгол Улсын Үндсэн хууль

Хоёр.Хууль тогтоомж

2.1.Ойн тухай хууль;

2.2.Байгаль орчныг хамгаалах тухай хууль;

2.3.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;

2.4.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;

2.5.Монгол Улсын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;

2.6.Хууль тогтоомжийн тухай хууль;

Гурав.Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт

3.1.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх”;

3.2.Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”;

Дөрөв.Бусад

4.1.Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан;

4.2.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, legalinfo.mn;

4.3.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 1212.mn;